



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 1/118

Улаанбаатар хот


Монгол Улсын Хүн амын насжилтын
асуудлаарх Үндэсний стратегийг хэрэгжүүлэх
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 156 дугаар тогтоолын 2, Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтын 19-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Хүн амын насжилтын асуудлаарх Үндэсний стратеги”-ийг 2020-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн салбарынхаа бодлого, төлөвлөлттэй уялдуулан батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулахыг холбогдох байгууллагууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.


3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын асуудлаарх Үндэсний хорооны гишүүд, нарийн бичгийн дарга, аймаг, нийслэлийн салбар хорооны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД, ХҮН АМЫН АСУУДЛААРХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА  С.ЧИНЗОРИГ



151200342

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Хүн амын асуудлаарх Үндэсний хорооны
даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны
өдрийн 1/18 дугаар тушаалын хавсралт



**“МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НАСЖИЛТЫН АСУУДЛААРХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ”-ИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2020-2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ. НАСЖИЛТЫГ УГТАХ СТРАТЕГИ									
ЗОРИЛТ 1.*		Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ							
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. 							
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
1	Эдийн засгийн тэргүүлэх болон ажиллах хүчний шингээлт ихтэй салбарт ажлын байруудыг бий болгох үр дүнд суурилсан үйл ажиллагаануудыг эрэмбэлэн төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлэх	Эдийн засгийн тэргүүлэх салбарт ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүний хэрэгжилтийн тайлан (Салбарын ажиллах хүчний нөөцийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгаа, статистик, гадаад АХ-ны квот тогтоох шийдвэр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудаар мэргэжилтэн бэлтгэх, гадаад орнуудад дадлагажигч илгээх, аж	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин-55.7хувь (Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхэлж байгаа хувь) (АХС, ҮСХ, 2019)	56.5-аас доошгүй хувь	57.5-оос доошгүй хувь	58.5-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	ХХААХҮЯ ¹ , УУХҮЯ ² , БХБЯ ³	ХНХЯ ⁴ , ЗТХЯ ⁵ , БОАЖЯ ⁶ , ЭХЯ ⁷

¹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
² Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
³ Барилга хот байуулалтын яам
⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
⁵ Зам, тээврийн хөгжлийн яам
⁶ Байгаль орчин аилал жуулчлалын яам
⁷ Эрчим хүчний яам

		ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ)							
2	Ажиллах хүчний шингээлт ихтэй боловсруулах болон хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, эрх зүйн акт (Ажиллах хүчний шингээлт ихтэй салбарыг татвар, зээл, хөрөнгө оруулалтын чиглэлээр дэмжсэн шийдвэр, хэрэгжүүлсэн арга хэмжээ)	- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого; - Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого; - Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого. (www.legalinfo.mn)	-	2-оос доошгүй шийдвэр батлагдсан байх	2-оос доошгүй шийдвэр батлагдсан байх	3-аас доошгүй шийдвэр батлагдсан байх	ХХААХҮЯ, УУХҮЯ, СЯ ⁸ , ҮХГ	ХНХЯ, ХЗДХЯ ⁹ , ЗТХЯ
3	Эдийн засгийн төрөлжсөн ажлын байруудыг орон нутагт бий болгоход тусгайлан дэмжлэг үзүүлэх	Төсөл, хөтөлбөр, арга хэмжээ; (хөнгөлөлттэй зээл, тусламж) Шинээр бий болсон ажлын байр	Сум хөгжүүлэх сангаас 2620 төсөлд (10.5 тэрбум төгрөг) хөнгөлөлттэй зээл олгож шинээр 2162 ажлын байр бий болсон. (2019) "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" төслийн хүрээнд шинээр 150 хүний ажлын бий болсон. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд гэрээт малчнаар ажиллах 259 өрхийн 425 иргэн хамрагдсан. (ХЭҮЗ, 2019)	3000-аас доошгүй шинэ ажлын байр	3000-аас доошгүй шинэ ажлын байр	3000-аас доошгүй шинэ ажлын байр	3000-аас доошгүй шинэ ажлын байр	ХХААХҮЯ, ХНХЯ, Аймгийн сумын ЗДТГ ¹⁰	УУХҮЯ, ХХҮЕГ ¹¹
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг	<u>Ажилгүйдлийн түвшин 10.0</u>	0.5-аас доошгүй	1-ээс доошгүй	1-ээс доошгүй	1-ээс доошгүй	ХНХЯ, ХХААХҮЯ	Бүх шатны ЗДТГ

⁸ Сангийн яам

⁹ Хууль зүй, дотоод хэргийн яам

¹⁰ Засаг даргын Тамгын газар

¹¹ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

	санхүүжилтийг үр өгөөж бүхий үйл ажиллагаанд илүү оновчтой хуваарилах, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах	бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ	(АХС, ҮСХ, 2019)	хувиар буурсан байх	хувиар буурсан байх	хувиар буурсан байх	хувиар буурсан байх		
5	Эмзэг бүлгийн иргэдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээ; (төсөл, хөтөлбөр, дэмжлэг тусламж, хөнгөлөлттэй зээл, татварын хөнгөлөлт) Шинээр бий болсон ажлын байр	Ажиллах хүчний оролцооны түвшин- 60.5 хувь	60.5-аас доошгүй хувь	61-ээс доошгүй хувь	61.5-аас доошгүй хувь	62-оос доошгүй хувь	ХНХЯ, ХХААХҮЯ, Бүх шатны ЗДТГ	СЯ, УУХҮЯ, ХХҮЕГ
6	Ажилд авах, ажлаас халахад нас, хүйсээр ялгаварлан гадуурхах байдлыг бууруулах	Нэвтрүүлэг контент, гарын авлага, брошур; Ажил олгогчдод чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;	"Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр"-т судалгаа хийх, сургалт зохион байгуулах ажлыг тусгасан.	-	2-оос доошгүй контент бэлтгэж, түгээсэн байх	2-оос доошгүй контент бэлтгэж, түгээсэн байх	2-оос доошгүй контент бэлтгэж, түгээсэн байх	ХНХЯ, ХХҮЕГ	Жендэрийн Үндэсний хороо, МҮЭХ, МАОЭХ
7	Ажлын бүтэн бус цагаар ажиллах, гэрээсээ, зайнаас ажиллах зэрэг уян хатан ажлын цагийн зохицуулалтыг бий болгох	Хөдөлмөрийн хууль (шинэчилсэн найруулга)-д орсон ажлын цагийн уян хатан зохицуулалт (бүлэг/зүйл/заалт)	Ажлын хэсэг ажиллаж Хөдөлмөрийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан.	-	-	-	Хууль батлагдсан байх	ХНХЯ, Ажлын хэсэг	Аймаг, нийслэлийн Засаг дарга, МҮЭХ, МАОЭХ

ЗОРИЛТ 1.2 Хөдөлмөр эрхэлж буй хүн амын нийгмийн баталгааг сайжруулна

Үйл ажиллагааны чиглэл

- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх;
- Ирээдүйн өсөн нэмэгдэх нийгмийн хамгааллын зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн баталгаат эх үүсвэрийг бүрдүүлэх.

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
8	Нийгмийн даатгалд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагууд НД-ын шимтгэл төлөлтийн тайланг бодит цалин хөлснөөс үнэн зөв, тайлагнах замаар даатгуулагч, ажилтны нийгмийн баталгааг хангах	Даатгуулагчид болон ажил олгогчид чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ; Төлөвлөгөөт хяналт шалгалт	Бага цалинтай ажиллагчдын хувь- 27.4 (ҮСХ, 1212.мн)(2018)	1-ээс доошгүй хувь буурсан байх	1-ээс доошгүй хувь буурсан байх	1-ээс доошгүй хувь буурсан байх	1-ээс доошгүй хувь буурсан байх	ХНХЯ, НДЕГ	Бүх шатны ЗДТГ
9	Тэтгэврийн даатгалд хамрагдсанаар ахмад насандаа амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр авах ач холбогдлыг танин мэдүүлэх	Тэтгэврийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах нөлөөллийн арга хэмжээ; Гарын авлага болон	Албан журмаар даатгуулагчдын тоо- 982.351 Сайн дураар даатгуулагчдын	2.5-аас доошгүй хувь өссөн байх	2.5-аас доошгүй хувь өссөн байх	2.5-аас доошгүй хувь өссөн байх	2.5-аас доошгүй хувь өссөн байх	НДЕГ	ХНХЯ, Бүх шатны ЗДТГ

	ажлыг зохион байгуулж, тэтгэврийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх	сурталчилгааны бусад арга хэрэгсэл;	тоо-185.986 (ҮСХ.1212.mn) (2019.XII)	оноос)	оноос)	оноос)	оноос)		
10	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлэх	Нийгмийн даатгалын багц хуульд тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих талаар туссан хууль/бүлэг/хэсэг/заалт	Ажлын хэсэг ажиллаж хуулийн төслийг боловсруулсан.	-	-	-	Хууль батлагдсан байх	ХНХЯ, Ажлын хэсэг	НДЕГ
ЗОРИЛТ 1.3		Зохистой төрөлтийг дэмжиж хүн амын насны тааламжтай бүтцийг урт хугацаанд тогтвортой хадгална							
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> • Төрөлтийг урамшуулж, гэр бүлийг дэмжих; • Гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээг дэмжих; • Гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх. 							
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
11	МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1, 104.1, 104.2, 105.1, 105.2, 106.1, 100.1, 100.2, 106.2, 106.3 зүйлүүд ¹² , Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.1, 11.2, 11.3.9-р зүйлүүдийн хэрэгжилтийн талаарх үнэлгээ, судалгаа хийх	Судалгааны тайлан, зөвлөмж (ажил олгогч болон ажилтнуудад тулгарч буй бэрхшээл, эрх, үүргийн зөрчлийг арилгахад чиглэсэн зөвлөмж) (хүүхэд төрүүлсэн, асарсан эх/эцгийн хөдөлмөрийн харилцаан дахь эрхүүд зөрчигдсөн байдлын түвшинг тодорхойлсон)	-	-	Үнэлгээ, судалгаа хийсэн байх Холбогдох 13 заалтын хэрэгжилтийн түвшин тодорхойлсон байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	ХНХЯ, Жендэрийн Үндэсний хороо	Судалгааны байгууллага
12	Зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрүүдэд хамруулах, ялангуяа 0-18 хүртэл насны 4, түүнээс олон хүүхэдтэй гэр бүлийг хамруулах квотыг нэмэгдүүлэх	Квотыг шинэчлэн баталсан тушаал/журам (бага насны олон хүүхэдтэй гэр бүлүүдийн амьдралын нөхцөл боломж сайжрах арга хэмжээ)	Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"	-	Квотыг 10-аас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлсэн байх	-	-	БХБЯ	НОСК ¹³ , ТОСК ¹⁴

¹² Жирэмсэн, амаржсан, бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ажлын байр хадгалах, амралтын ба хөдөлмөрийн цаг, амрах ажиллах нөхцөл, орлого, нийгмийн хамгаалал зэргийг зохицуулсан заалтууд

¹³ Нийслэлийн орон сууцны корпораци

¹⁴ Төрийн орон сууцны корпораци

			0-18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийн ангилалд түрээсийн орон сууц хуваарилах квот 5 хувь. (нийслэл ба орон нутагт ялгаваргүй)						
ХОЁР. АХМАД НАСТНЫ АЖ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИ									
ЗОРИЛТ 2.1		Ахмад настны хөгжилд оролцох оролцоог хангах, түүний үр шимээс хүртэх боломжийг өргөжүүлэх замаар тэдний орлогын баталгаат байдлыг сайжруулна							
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Ахмад настны боломж, чадавхдаа тохирсон ажил, ахуй эрхлэх санаачлагыг дэмжих; Нийгмийн баялгийн дахин хуваарилалтыг оновчтой болгох замаар ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх. 							
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
13	Ахмад настны хуулийн 9 ¹⁵ дүгээр зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан, санал зөвлөмж	Ахмад настны хууль 2017 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн. (үнэлгээ хийгдээгүй)	-	Үнэлгээ хийсэн байх	Үнэлгээний үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	Үнэлгээний үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	ХНХЯ	ХХҮЕГ, ХНХСИ, МАХХ
14	Ахмад настны боломж, чадамжид тохирсон ажлын байрны судалгаа хийх	Судалгааны тайлан, зөвлөмж; (ахмад настны чадамжид тохирсон ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гарсан зөвлөмж)	-	-	Судалгаа хийж, зөвлөмж гаргасан байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	ХНХЯ, ХНХСИ	ХХҮЕГ, ХАБЭМТ, МАХХ, судалгааны байгууллага
15	Ахмад настны боломж, чадамжид тохирсон ажлын байр бий болгосон ажил олгогчийг урамшуулал, дэмжлэгт хамруулах (Ахмад настны тухай хуулийн 9.5 дахь хэсэг) ¹⁶	Урамшуулал, дэмжлэгт хамруулах шийдвэр; Ажил олгогчид олгосон урамшуулал, дэмжлэгийн төрөл хэлбэр (хөнгөлөлт, чөлөөлөлт, зээл тусламж)	<u>Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн түвшин:</u> ХЭТ ⁵⁵⁻⁵⁹ =45.9% ХЭТ ⁶⁰⁺⁶⁴ =21.1% ХЭТ ⁶⁵⁻⁶⁹ =15.5% (ҮСХ, АХС 2018)	Насны бүлэг бүрт 1-ээс доошгүй хувиар нэмэгдсэн байх	Насны бүлэг бүрт 1-ээс доошгүй хувиар нэмэгдсэн байх	Насны бүлэг бүрт 1-ээс доошгүй хувиар нэмэгдсэн байх	Насны бүлэг бүрт 1-ээс доошгүй хувиар нэмэгдсэн байх	Бүх шатны ИТХ, ЗДТГ	Яам, агентлагууд
16	Ахмад настны ур чадвар,	Зохион байгуулсан	"Насан туршдаа	-	2000-аас	2000-аас	2000-аас	Насан	МАХХ,

¹⁵ 9 дүгээр зүйл. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

¹⁶ 9.5. Ахмад настны санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсдын 50-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршоонд Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хөрөнгө, зээл олгож дэмжлэг үзүүлж болно.

	мэдлэгийг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилтот, сэдэвчилсэн сургалт зохион байгуулах	сургалтууд	суралцахуйг дэмжих хөтөлбөр” батлагдсан.		цөөнгүй ахмад настан хамруулсан байх	цөөнгүй ахмад настан хамруулсан байх	цөөнгүй ахмад настан хамруулсан байх	туршийн боловсролын төв, ХХҮЕГ	Сургалтын байгууллага
17	Ахмад настны талаарх статистик тоо мэдээлэл (ангилал бүхий)-ийг бий болгох, мэдээлэл цуглуулах маягыг боловсронгуй болгож шинэчлэн батлуулах	Маягт батлах тухай тушаал/шийдвэр; Батлагдсан маягт/загвар	Мэдээллийн сан (Хүн амын өрхийн мэдээллийн сан, Ахмад мэргэжилтэн зөвлөх үйлчилгээ, асрамж, халамжийн үйлчилгээ г.м)	-	Маягт батлагдсан байх	-	-	ХНХЯ, ХНХСИ	ҮСХ ¹⁷ , ХХҮЕГ
18	Тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын амьжиргааны түвшний өөрчлөлттэй уялдуулан тухай бүр нэмэгдүүлэх	Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгүүлэх талаар батлагдсан тогтоол шийдвэр; Тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгийн хувь/өсөлт	Дундаж тэтгэвэр /мян.төг/ 2019 - Өндөр насны тэтгэвэр-383.0 - Тахир дутуугийн тэтгэвэр-290.7 - Тэжээгчээ алдсаны тэтгэвэр- 298.7 - Цэргийн алба хаасны тэтгэвэр-630.1	Тогтоол, шийдвэр батлагдсан байна	Тогтоол, шийдвэр батлагдсан байна	Тогтоол, шийдвэр батлагдсан байна	Тогтоол, шийдвэр батлагдсан байна	ХНХЯ, СЯ	НДЕГ, ХХҮЕГ
19	Ахмад настанд зориулсан асрамжийн үйлчилгээний буюу “Асрамжийн газарт тавигдах стандарт”-ын хэрэгжилтийг үнэлэх	Стандартын хэрэгжилтийн үнэлгэний тайлан, санал зөвлөж; Магадан итгэмжлэл	2017 онд “Асрамжийн газрын магадлан итгэмжлэл”-ийг хийх хүрээнд стандартад үнэлгээ хийсэн.	12 төвд үнэлгээ хийсэн байх	-	-	-	ХХҮЕГ, МХЕГ ¹⁸	ХНХЯ, ЭМЯ
ЗОРИЛТ 2.2		Хүн амыг эрл насжихад бэлтгэх, эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар ахмад настны өвчлөлийг бууруулна.							
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Хүн амыг эрл насжихад бэлтгэх; Эмнэлгийг тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байх. 							
№	Үйл ажиллагаа	Үтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
20	“Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургагч багш бэлтгэх (эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн чиглэлээр)	Зохион байгуулсан сургалтууд; Бэлтгэсэн сургагч багш	2018 онд ХНХ-ын салбарын болон бусад байгууллагын 80 гаруй төлөөллийг хамруулан сургалтыг зохион байгуулсан.	-	60-аас доошгүй сургагч багш бэлтгэсэн байх	60-аас доошгүй сургагч багш бэлтгэсэн байх	60-аас доошгүй сургагч багш бэлтгэсэн байх	ХНХЯ, МАХХ	Төрийн байгууллага, МҮХАҮТ, АОЭНХ, МҮЭХ

¹⁷ Үндэсний статистикийн хороо

¹⁸ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

21	Аймаг, дүүрэг, сум бүрт нийтийн биеийн тамирын талбай байгуулах, дасгалын тоног төхөөрөмжөөр орчноо тохижуулах, тогтмол ажиллуулах	Шинээр талбай байгуулах болон тоног төхөөрөмжөөр тохижуулах шийдвэр; Шинээр байгуулагдсан буюу тохижуулсан талбай; (Сум, дүүргийн Засаг дарга нарын аймаг, нийслэлийн Засаг нартай байгуулах хамтран ажиллах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх)	Талбай байгуулсан болон тохижилт хийсэн баг/хорооны тоо тодорхойгүй	-	Гэрээнд тусгасан байх Шинээр 5-аас доошгүй талбай бий болсон байх	Шинээр 5-аас доошгүй талбай бий болсон байх	Шинээр 5-аас доошгүй талбай бий болсон байх	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Баг, хорооны Засаг дарга
22	Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ахмад настны тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх ¹⁹	Ахмад настны спорт клубээс ЭМД-аар авсан үйлчилгээ; ЭМД-аас санхүүжилт олгосон /тайлан мэдээ	Магадлан итгэмжлэлд тэнцсэн спорт клубын тоо-13;	Үйлчилгээ авсан иргэдийн 5-аас доошгүй хувь	Үйлчилгээ авсан иргэдийн 10-аас доошгүй хувь	Үйлчилгээ авсан иргэдийн 15-аас доошгүй хувь	Үйлчилгээ авсан иргэдийн 20-иос доошгүй хувь	ЭМЯ, ЭМДЕГ ²⁰	ХНХЯ, БСШУСЯ ²¹
23	Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн баг, эмч, ажилтнуудыг чадавхжуулах болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтууд; (эмч, сувилагч, сэргээн засалч, хөдөлгөөн засалч гэх мэт төрлөөр)	ХНХЯ-наас асрамж халамжийн чиглэлээр ажиллаж буй баг, эмч, сувилагч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2019 онд зохион байгуулсан.	80-аас доошгүй хүн хамруулсан байх	80-аас доошгүй хүн хамруулсан байх	80-аас доошгүй хүн хамруулсан байх	80-аас доошгүй хүн хамруулсан байх	ЭМЯ, ЭМХТ ²² , ГҮТ ²³	Сонгогдсон сургалтын байгууллага, Олон улсын төсөл, хөтөлбөр
24	Урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах маягтын загвар батлуулах	Мэдээллийн сан; Батлагдсан маягт, загвар	Мэдээллийн сан байхгүй	-	-	Мэдээллийн сан бүрдүүлсэн байх	-	ХНХЯ, ЭМЯ	ГҮТ, ЭМХТ, ХХҮЕГ

¹⁹ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.4 дэх заалт (Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт ЭМД-аар үйлчилгээ авах тухай)

²⁰ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

²¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

²² Эрүүл мэндийн хөгжлийн төв

²³ Геронтологийн үндэсний төв

25	Асаргаа үзүүлэгчдэд хэвтрийн, хүнд өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай хүний өвчний төрөл, хэлбэрт тохирсон тусламж үзүүлэх цуврал цахим хичээл бэлтгэж, түгээх	Цуврал цахим хичээлүүд;	-	-	Цахим хичээл боловсруулж, бэлтгэсэн байх	5000-аас доошгүй хувийг түгээсэн байх	-	ЭМЯ, ХНХЯ, ГҮТ	Эрүүл мэндийн байгууллага
26	"Ахмад настнуудын эрүүл мэндийн мэдлэг, дадал, хандлага"-ын судалгаа хийх	Судалгааны тайлан; <u>Дараах үзүүлэлтийг тодорхойлсон:</u> -Хоол тэжээлийн дутагдалтай ахмадын хувь; -Эрүүл мэндийн нэмэгдэл бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээний түвшин; -Өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадлын түвшин; -Эмийн зохистой хэрэглээний мэдлэг, дадлын түвшин; -Зөв, эрүүл хооллолтын мэдлэг, дадлын түвшин	Хоол тэжээлийн дутагдал үүсэх эрсдэлтэй болон дутагдалтай ахмад настнуудын мэдээлэл 2014 оноос гарч эхэлсэн. <u>Бусад мэдээлэл боломжгүй.</u>	-	Судалгаа хийсэн байх Үзүүлэлтийг тодорхойсон байх	-	-	ЭМЯ, ГҮТ, НЭМҮТ	Судалгааны байгууллага
27	Ахмад настны тухай хуулийн 10.1.6. ²⁴ дахь заалтыг хэрэгжүүлэх, настны эмч бэлтгэх	Настны эмч бэлтгэх, мэргэшүүлэх сургалт, курс; Ахмад настны кабинет, бэлтгэгдсэн эмч; (эмч, сувилагч, ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, ур чадвар эзэмшсэн ажилтан)	- Үндэсний төв-1 - настны кабинет-9 (аймагт 8, дүүрэг-1) - настны эмч тоо-12,(ГҮТ-3, аймагт-8, дүүрэгт-1)	-	Шинээр 2-оос доошгүй кабинет	Шинээр 2-оос доошгүй кабинет	Шинээр 2-оос доошгүй кабинет	ЭМЯ, ЭМХТ	ГҮТ
28	ЭМД-ын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМД-ын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шийдвэр; Хөнгөлөлттэй олгосон эм, эмнэлгийн хэрэгсэлд зарцуулсан санхүүжилт	2019 онд ЭМД-ын сангаас Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал 40,548.2 сая төгрөг зарцуулсан. (ҮСХ.1212.mn)	Санхүүжилт өмнөх оноос нэмэгдэж батлагдсан байх	Санхүүжилт өмнөх оноос нэмэгдэж батлагдсан байх	Санхүүжилт өмнөх оноос нэмэгдэж батлагдсан байх	Санхүүжилт өмнөх оноос нэмэгдэж батлагдсан байх	ЭМЯ, ЭМДЕГ	Сангийн яам

²⁴ ахмад настны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ахмад настны кабинет, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд ахмад настны эмч, эсхүл ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр мэргэжил, ур чадвар эзэмшсэн эмч ажиллуулах

ЗОРИЛТ 2.3		Олон нийтэд ахмад настны талаарх эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлж, тэднийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд ажиллаж, амьдрах харилцан бие биедээ туслах, утга төгөлдөр амьдрах ээлтэй орчинг бүрдүүлнэ							
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Насжилт, ахмад настны талаар олон нийтийн дунд эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлэх замаар тэдний гэр бүл, нийгэм хамт олныхоо дунд амар тайван амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх; Ахмад настны орон байрны хангамжийг сайжруулах, тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн орчны дэд бүтэц, тээвэр, үйлчилгээг хөгжүүлэх. 							
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2022	2023		
29	Насжилт, ахмад настны эрх хамгааллын чиглэлээр зорилтот цуврал нэвтрүүлэг хийх	Нэвтрүүлэг/контент (бэлтгэж түгээсэн)	<u>Зорилтот нэвтрүүлэг байхгүй</u>	-	12-оос доошгүй контент бэлтгэж түгээх	12-оос доошгүй контент бэлтгэж түгээх	12-оос доошгүй контент бэлтгэж түгээх	ХНХЯ, МҮОНРТ	ГБХЗХГ, МАХ
30	Олон нийтэд ахмад настны талаарх эерэг ойлголт, хандлагыг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэх	Зөвлөгөө мэдээллийн төвийн үйл ажиллагаа; (ухуулан таниулах, сурталчлах, сургалт зохион байгуулах гарын авлага, брошур) Олон нийтийн дунд болон цэцэрлэг, сургуулиудад зохион байгуулсан энэ төрлийн арга хэмжээ;	Гэр бүлийн хөгжил, ахмад настны төвүүдээр 2019 жилийн эцсийн байдлаар 249204 иргэд үйлчлүүлсэн байна. Үүнээс: Ахмад настны төв/ танхимаар үйлчлүүлсэн хүний тоо 173491 байна	30-аас доошгүй арга хэмжээ	30-аас доошгүй арга хэмжээ	30-аас доошгүй арга хэмжээ	30-аас доошгүй арга хэмжээ	ХНХЯ, ГБХЗХГ ²⁵ , МАХ	ГБХЗХГ-ын харьяа газар хэлтэс, Хэвлэл мэдээллийн байгууллага, Насан туршийн боловсролын төв
31	Ахмад настны эрхийн асуудлаар суурь судалгаа хийх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Судалгааны тайлан, зөвлөмж;	Хараат бус, бие даасан байдлын талаар хийгдсэн судалгааны мэдээлэл байхгүй	-	Судалгаа хийсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	ХНХСИ, МАХ	Судалгааны байгууллага
32	Насжилт, ахмад настны талаарх олон нийтийн мэдлэг хандлагын болон ахмад настуудын сэтгэл ханамжийн түвшинг үнэлэх, түүвэр судалгаа хийх	Судалгааны ажлын тайлан, санал зөвлөмж, тандалтын дүн; (Ахмад настны сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон тайлан)	<u>Судалгааны мэдээлэл байхгүй</u>	-	Судалгаа хийсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	Судалгааны үр дүнгээс гарсан 2-оос доошгүй зөвлөмжийг хэрэгжүүлсэн байх	ХНХЯ	Судалгааны байгууллага
33	Ахмад настанд ээлтэй байгууллага, хамт олныг	Батлагдсан арга зүйн удирдамж/журам;	Шалгаруулалт зохион байгуулах арга зүй,	-	Шалгуур үзүүлэлт	-	-	ХНХЯ	ЭМЯ

²⁵ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

	шалгаруулах арга зүй, шалгуурыг бий болгох	Батлагдсан шийдвэр, тусгагдсан шалгуур үзүүлэлт	удирдамж/журам байхгүй.		батлагдсан байх				
34	Үйлчилгээний байгууллага, орон сууц, нийтийн тээвэр, явган хүний зам, талбайн ахмад настанд хүртээмжтэй байдалд үнэлгээ хийж, түүнд тулгуурлан холбогдох стандартуудыг шинэчлэх, боловсронгуй болгох	Үнэлгээний тайлан, зөвлөмж; Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан стандарт;	Явган хүний зам, талбайн төлөвлөлт болон техникийн шаардлага MNS 6808:2019 стандартыг 2019-12-25 өдөр баталж, 2020-01-06-ны өдрөөс мөрдөж эхэлсэн:	-	-	Үнэлгээ хийсэн байх	Холбогдох стандарт шинэчлэн батлуулсан байх	ХНХЯ, БХБЯ, ЗТХЯ, МХЕГ	Төрийн бус байгууллага
35	Ахмад настны хуулийн 14.5.4 ²⁶ дэх заалтыг хэрэгжүүлэх	Ахмад настанд орон сууц хуваарилах, олгохтой холбоотой гаргасан тушаал, шийдвэр; Ахмад настанд олгосон орон сууц; Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр баригдсан орон сууцны хороолол, хотхоны талаарх судалгааны тайлан	Засгийн газрын 2019 оны 223 дугаар "Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай" тогтоолоор "Буянт-Ухаа-2" 972 айлын орон сууцыг нийслэлийн орон сууцны санд шилжүүлсэн. Үүнээс: Ахмад настны ангиллын түрээслээд өмчлөх хэлбэрээр 36, энгийн түрээсээр 40 иргэнийг хамруулсан.	Хамрагдсан ахмад настны тоо өмнөх оноос өссөн байх	Хамрагдсан ахмад настны тоо өмнөх оноос өссөн байх	Хамрагдсан ахмад настны тоо өмнөх оноос өссөн байх	Хамрагдсан ахмад настны тоо өмнөх оноос өссөн байх	Аймаг, нийслэлийн ЗДТГ	БХБЯ, ТОССК, НОСК

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

²⁶ 14.5.4.аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон сууц барих аж ахуйн нэгжийн удирдлагатай тохиролцон шинээр баригдах орон сууцны дэд бүтцэд төсвөөс оруулсан хөрөнгө оруулалттай тэнцэх хэмжээний үнийн дүнтэй орон сууцыг эзэмшилдээ авах, эхний ээлжид орон байргүй ахмад настанд хөлслүүлэх, эзэмшүүлэх, хүүхэдтэйгээ хамтран төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдүүлэх;